



- Сургуулийн орчин дахь хүчирхийлэл гэдэг нь сургуулийн дотоод гадаад орчинд хүүхэд гэмтэх, хүчирхийлэлд өртөх, хүчинд автах, хорионд орох, мэдэлд оруулах уруу татагдах, нэр хүнд унагаах доромжлох, айлган сүрдүүлэх, албадах албадан зарах, бэлгийн хүчирхийлэлд өртөх, гадуурхагдах, цахим сүлжээнд гадуурхагдах, интернэт орчинд садар самуунд татагдах бие сэтгэл зүй, эд хөрөнгөд хохирол учруулах бүхий л үйлдлийг хэлнэ.

01

Сургуулийн орчин дахь хүчирхийлэл

- Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороонд бүртгэгдсэн мэдээллийг журмын дагуу авч хэлэлцээд хүчирхийлэлд өртсөн, хүчирхийлэл үйлдсэн хүүхдийн талаар зохих арга хэмжээ авах журмыг мөрдлөг болгоно. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд арга хэмжээ авах асуудлыг яаралтай шийдэх хэрэгтэй гэж үзвэл сургуулийн захирал даруй зохих арга хэмжээг авна.

02

Яаралтай арга хэмжээ авах

- Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг хариуцсан алба нь хичээлийн эрхлэгч, мэргэжлийн зөвлөгч, эрүүл мэндийн багш, сургуулийн нийгмийн ажилтан(сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг эрхэлсэн багш), эцэг эхийн төлөөллөөс бүрдэнэ.
- Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг бүртгэгдвэл Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг хариуцсан алба(тус албаны гишүүн) болсон явдлыг тодруулах судалгаа явуулна. Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэргийг сургуулийн захирал бие даан шийдэх боломжтой эсэх, Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороог хуралдуулах шаардлагатай эсэхийг шийднэ.

03

Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг хариуцсан алба

- Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, асран хамгаалагч сургуулийн орчинд үүссэн хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороогоор шийдүүлэх хүсэлгүй, жижиг хэргийг сургуулийн захирал бие даан шийднэ.
- Сургуулийн захирал бие даан шийдвэр гаргасан тохиолдолд хэрэгт холбогдсон хүүхдүүдийн харилцааг сэргээх арга хэмжээ, сургалтын хөтөлбөр зохион байгуулна.

04

Сургуулийн захирал асуудлыг бие даан шийдвэрлэх тухай

- Сургуулийн орчин дахь хүчирхийллийг хянан шалгах хороо гэдэг нь сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд арга хэмжээ авч, сахилгын хариуцлага хүлээлгэх, хэрэгт холбогдогч талуудын хоорондох маргааныг зохицуулах үүрэг бүхий боловсролын газрын харъяа шүүх байгууллага юм.
- Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороо нь сургуулийн орчинд гарсан хүчирхийллийн хэргийг хянан шалгаж, хүчирхийлэлд өртсөн, хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд зохих арга хэмжээг авна.

05

Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороо

CONTENTS

Гарчиг

I СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТӨРӨЛ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

1. Сургуулийн орчин дахь хүчирхийллийн төрөл, кейс 03
2. Сургуулийн орчин дахь хүчирхийллийн үед илрэх шинж тэмдэг, түүнээс урьдчилан сэргийлэх 05

II Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэргийг шийдвэрлэх

1. Сургуулийн орчинд гарсан хүчирхийллийг мэдэгдэх 07
2. Шуурхай арга хэмжээ 08
3. Болсон явдлын талаар судалгаа явуулах 09
4. Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг хариуцсан албаны хяналт шалгалт 10
11
5. Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороогоор хэлэлцүүлж, арга хэмжээ авах 14
6. Талуудын хоорондын харилцааг сэргээх, маргаан зохицуулах

[Хавсралт]

1. Сургуулийн орчин дахь хүчирхийллийн тухай мэдэгдэх / тусламж авах байгууллага 15
2. Сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд дэмжлэг үзүүлэх байгууллага 16

I

СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТӨРӨЛ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ



1 Сургуулийн орчин дахь хүчирхийллийн төрөл, кейс

• Сургуулийн орчин дахь хүчирхийлэл гэж юу вэ?

Сургуулийн орчин дахь хүчирхийлэл гэдэг нь сургуулийн дотоод-гадаад орчинд хүүхдэд учруулсан бие, сэтгэл зүй, эд хөрөнгийн бүхий л хохирлыг хэлнэ.

※ Жижиг зүйлээр зовоож шаналгах, тоглоом болгон хийсэн үйлдэл хүртэл сургуулийн орчин дахь хүчирхийлэлд хамаарна.

• Сургуулийн орчин дахь хүчирхийллийн төрөл, кейс

Доор нэр заасан сургуулийн орчин дахь хүчирхийллийн нэр төрлөөс гадна бие-сэтгэл зүй-эд хөрөнгөнд хохирол учруулсан бүхий л үйлдэл сургуулийн орчин дахь хүчирхийлэлд багтана.

Биеийн хүчирхийлэл

- Гар хөлөөрөө цохиж, өшиглөх(гэмтээж, зодох)
- Өрөөнөөс гарах аргагүй болгох(цагдан хорих)
- Албадан(зодож, айлган сүрдүүлэх) дагуулж явах(мэдэлд оруулах)
- Хуурч мэхлэн, уруу татан дагуулж явах(уруу татах)
- Хүүхдэд хүчирхийлэлд өртөж байна гэсэн ойлголт төрүүлэхүйц тоглоом тохуу гэсэн нэрийн дор чимхэж, цохиж, хүчтэй түлхэх үйлдэл

Үг хэлээр доромжлох

- Олон хүний нүдэн дээр нэр хүнд унагаахуйц юм ярьж(зан характер, чадвар, ахуй амьдрал зэрэг), интернэт, SNS орчинд тийм агуулга бүхий зүйл тавих(нэр хүнд унагаах)
※ Хэлсэн, бичсэн зүйл нь үнэн ч гэсэн уг үйлдэл нь өөрөө хэл амаар доромжлох хүчирхийллийн хэлбэрт багтана
- Олны өмнө үг хэлээр байнга доромжлох(царай өнгө төрхөөр нь элэглэн шоолж, тэнэг мангараар нь дуудан доош нь хийх), ийм агуулга бүхий бичвэр интернэт, SNS орчинд тавих(доромжлох)
- Бие махбодид хохирол учруулахуйц юм ярьж, айдас хүргэсэн мессеж явуулах(айлган сүрдүүлэх)

Мөнгө дээрэмдэх(дээрэм)

- Буцааж өгөх бодолгүйгээр мөнгө нэхэх
- Хувцас, бичиг хэрэгслийн эд зүйлсийг нь зээлж авчихаад буцааж өгөхгүй байх
- Эд хэрэгслийг нь албаар эвдэж хэмхлэх, мөнгө олж ир гэж шаардах

Албадах

- Албадлагад нь автан юм худалдан авч өгөх, интернэтээ ашиглуулах(Хүүхдүүд “Нарийн боовны улаач, WiFi shuttle” гэж нэрлэдэг), гэрийн даалгаврыг нь хийж өгөх, оронд нь тоглоом тоглох, албадан зарах(албадан зарах)
- Зодон, айлган сүрдүүлж бусдын эрхийг зөрчих, хийх албагүй ажил хийлгэх(албадах)

Гадуурхах

- Хамт олноороо зориуд байнга зугтаж, зайлсхийх
- Дургүйгээ үгээр илэрхийлж шоолох, ёжлох, ичээх, айлгах, эвгүй байдалд оруулах, басамжлан инээх
- Өөр хүүхдүүдтэй нийлүүлэхгүй байх

Бэлгийн хүчирхийлэл

- Зодож айлган сүрдүүлэх, хүчиндэх, үүнтэй ижил төстэй бэлгийн үйлдэл хийх
- Зодож, айлган сүрдүүлэхдээ биед нь хүрч, шалиг завхай үгээр элэг доог хийх
- Шалиг завхай үг хэлээр доромжлон элэг доог хийж, ичээх

Кибер орчин дахь хүчирхийлэл

- Зарлалын самбар, мэйл, чат, мессежерт харааж зүхэх, худал юм тавьж доош нь хийх(Кибер орчинд үг хэлээр доромжлох)
- Кибер орчинд доош нь хийх зорилгоор худал юм бичиж нэр хүндийг нь унагаах(кибер орчинд нэр хүнд унагаах)
- Кибер мони, мөнгө булаах гэдэг нь ихэвчлэн кибер орчинд WiFi shuttle, game money-г булааж авахыг хэлнэ(кибер дээрэм)
- Кибер орчинд хүлээж авах хүсэлгүй мессеж, зураг, видео байнга илгээж эвгүй байдалд оруулж, айлган сүрдүүлэх бүхий л үйлдэл(Кибер стокинг)
- Интернэт мессеж, SNS-ын групп чатнаас гарах аргагүй болгож, нүүрэн дээр нь доромжилж, ярианд оролцох аргагүй болгох(кибер гадуурхал, кибер орчинд цагдан хорих)
- Интернэт орчинд өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр биеийн онцгой хэсгийг харуулсан зураг тавьж, нэр хүндэд сөргөөр нөлөөлөх зураг, видео бичлэг явуулж тараан эвгүй байдалд оруулах(кибер орчинд видео бичлэг тараах)

• Сургуулийн орчин дахь хүчирхийллийн үед илрэх шинж тэмдэг¹⁾

Хүүхдэд дараахь шинж тэмдэг илэрч байгаа эсэхийг анхааралтай ажиглана.

※ Ганц шинж Албадах сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн гэдгийг баталж чадахгүй тул тал талаас нь авч үзэж шийдвэр гаргах хэрэгтэй.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд илрэх шинж тэмдэг

- ✓ Ангийн хүүхдүүдийнх нь тухай яриа өдөхөд маш эмзэг хүлээж авна.
- ✓ Мэлэрч, юманд анхаарал төвлөрүүлж чадахаа болих.
- ✓ Сургууль, дамжаагаа солих тухай ярих.
- ✓ Халаасны мөнгө урьд өмнөхөөс их нэхэж, смарт утасных нь төлбөр их гарна. Смарт утсаа сэтгэл түгшсэн байдалтай харах нь ажиглагдана.
- ✓ Дадлага сургалтын төв, сайн санааны ажил зэрэг хамт олны ажилд оролцохоос зайлсхийнэ.

Хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд илрэх шинж тэмдэг

- ✓ Үе үе хүүхэд зодох, амьтан зовоох байдал харагдана.
- ✓ Хурц зан характертай, гэнэт ямар нэгэн үйлдэл хийж, хүн хүн лүү үсчин дайрдаг.
- ✓ Хүчирхийлэл, тоглоом шоглоомыг үл ялгаж, байнга асуудал үүсгэдэг.
- ✓ Хараалын үг их хэрэглэж, үеийнхээ хүүхдүүдийг доош нь хийсэн үг хэллэг байнга хэрэглэдэг.
- ✓ SNS орчинд бусдыг доромжлон доош нь хийсэн үг хэллэг ямар ч эргэлзээгүйгээр тавидаг.

• Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь

Дараахь зааврын дагуу хүүхдээ сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.

- 1) Хүүхдэд үеийнхээ хүүхдүүдийг шоолж, санаатайгаар гадуурхаж, зовоох нь сургуулийн орчин дахь хүчирхийлэл болно гэдгийг ойлгуулна.
- 2) Сургуулийн орчин дахь хүчирхийллийн гэрч болох юмуу болсон явдлыг мэдсэн тохиолдолд багш болон эцэг эхдээ заавал хэлэхийг анхааруулна.
- 3) Сургуулийн орчин дахь хүчирхийллийн асуудалд зөвлөгөө өгөх байгууллагын тухай мэдээллийг урьдчилан зааж өгнө.
- 4) Эцэг эхчүүдэд зориулсан сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтад идэвхитэй оролцоно.
- 5) Хүүхдийнхээ анги даасан багштай байнга холбоотой байж, хүүхэд тань сургуульдаа сайн явж байгаа эсэхэд байнга анхаарал хандуулна.


1) ???

II

СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХ



Сургуулийн орчинд үүссэн хүчирхийллийн хэргийг дараахь журмын дагуу шийдвэрлэнэ



• Сургуульд мэдэгдэх арга

- ✓ **Аман** : Сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн хүүхэд, асран хамгаалагч биеэр ирж анги даасан багш болон сургуулийн орчин дахь хүчирхийллийн асуудал хариуцсан багшид мэдэгдэнэ.
- ✓ **Мэдээлэл хүлээн авах хайрцаг** : Сургууль дотор байрлуулсан санал хүсэлт, мэдээлэл хүлээн авах хайрцаганд мэдээллийн хуудас хийж мэдээлэл өгнө.
- ✓ **И-мэйл** : Анги даасан багш, сургуулийн орчин дахь хүчирхийллийн асуудал хариуцсан багш, сургуулийн и-мэйл хаягаар мэдээлэл өгнө.
- ✓ **Вэб хуудас** : Сургуулийн вэб хуудасны зарлалын самбарт нууц зурвас бичиж мэдээлэл өгнө.
- ✓ **Гар утас** : Хүчирхийллийн хэрэг хариуцсан албаны гишүүн(хичээлийн эрхлэгч, сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг хариуцсан багш, эрүүл мэндийн багш, зөвлөгч багш)-д хэлэх юмуу сургуулийн утсанд мессеж, дуут мессеж илгээж, утсаар мэдэгдэнэ.
- ✓ **Сургуулийн цагдаа** : Харьяа сургуулийнхаа цагдаад мессеж болон утсаар мэдээлэл өгнө.

• Сургуулиас гадуурхи байгууллагад мэдээлэл өгөх арга

- ✓ **Сургуулийн орчин дахь хүчирхийллийн тухай мэдээлэл өгөх төвийн 117 дугаарын утас** : Орон нутгийн кодгүйгээр 117 дугаарын утсанд залгаж хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх тухай зөвлөгөө авах юмуу сургуулийн орчин дахь хүчирхийллийн тухай мэдээлэл өгнө.



Орон нутгийн кодгүйгээр 117 дугаарт залгана



#0117



Аюулгүй байдал Dream(117 гэж хайна)-д мэдээлэл өгнө



117 төв дээр өөрийн биеэр ирж мэдээлэл өгч зөвлөгөө авна

- ※ Сургуулийн орчинд гарсан хүчирхийллийн тухай мэдээлэл хүлээн авах төв 24 цагаар ажилладаг. Төв нь хүчирхийлэлд өртсөн хүүхдийг яаралтай аврах, хэргийн тухай байцаалт явуулах, хуулийн зөвлөгөө өгөх, тусгай байранд байрлуулах үйлчилгээ үзүүлнэ.

- ✓ **Кибер орчин дахь хүчирхийллийн тухай мэдээлэл өгөх** : Өсвөр насны хүүхдэд зөвлөгөө өгөх кибер төв(#1338), Цагдаагийн ерөнхий газрын Кибер орчны аюулгүй байдлыг хангах төв(www.cyber.go.kr)

- ※ Интернэтэд тавигдсан бичвэрийн агуулга бүхий дэлгэцийг capture хийж, бичвэр тавьсан хүний ID нь нууцлагдсан бол интернэт болон IP хаягийг нь тэмдэглэн авч кибер орчин дахь хүчирхийллийг баримтжуулна.

[Хавсралт] Таны хүүхэд сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн бол дараахь зааврын дагуу арга хэмжээ аваарай

- Хүүхдийнхээ яриаг нь тогтон сонсож, ойлгохыг хичээнэ.
 - "Миний хүүхэд ганцаардаад их хэцүү байсан байх даа. Болсон явдлыг ээж, аавдаа хэлж өгсөнд баярлалаа. Ээж, аав хоёр нь чамд яаж туслах уу?" гэж асуун шархалсан сэтгэлийг нь тайвшруулна.
- Сэтгэлээ барьж, хүүхдээ тайвшруулаад сайн ярилцана.
 - Хүүхэд хүчирхийлэлд өртсөн тухайгаа эцэг эхдээ хэлбэл загнуулна, эцэг эх нь яаж ч чадахгүй гэсэн бодлын улмаас айдас өвөрлөж явдаг. Иймээс тулган асууж шалгаалгүйгээр дотно дулаан үгээр ярилцаарай.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд ч бас шалтгаан бий гэсэн бодлоос зайлсхийнэ.
 - "Чи өөрийнхөө буруугаас болж хүчирхийлэлд өртөө биз." гэсэн үг хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж, өөртөө итгэх итгэлийг нь үгүй болгодог.

Хэрэгт холбогдогч талуудад авах шуурхай арга хэмжээ

Сургуулийн захирал шаардлагатай гэж үзвэл сургуулийн орчин дахь хүчирхийлэлд холбогдогч талуудад дараахь шуурхай арга хэмжээг авна.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах шуурхай арга хэмжээ	Хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд авах шуурхай арга хэмжээ
<ul style="list-style-type: none"> • Сургуулийн болон гадны зөвлөгөө өгөх мэргэжлийн байгууллагад хандаж сэтгэл зүйн зөвлөгөө авахыг санал болгоно. • Түр хамгаалалтад авна. • Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах бусад арга хэмжээ авна(Хүчирхийлэлд өртсөн, хүчирхийлэл үйлдсэн хүүхдийг тусгаарлах зорилго бүхий тусгай хөтөлбөр зохион байгуулна). 	<ul style="list-style-type: none"> • Хүчирхийлэл үйлдсэн хүүхдээр хийсэн хэргийнхээ талаар уучлал хүссэн бичгийг гараар нь бичүүлнэ. • Холбогдох байгууллагад мэдээлэл өгч гомдол гаргасан хүүхэдтэй уулзах, айлган сүрдүүлэх, өшөө авах зэрэг үйлдэл хийхийг хориглоно. • Сургууль дээр ажил хийлгэнэ. • Сургуулийн болон гадны мэргэжлийн зөвлөгөө өгөх байгууллагаас зохион байгуулдаг тусгай сургалтад хамруулж, сэтгэл зүйн эмчилгээ хийлгэнэ. • Хичээлд суух эрхийг нь түр хаана.

※ Шуурхай арга хэмжээнд хамрагдахаас татгалзах юмуу зайлсхийсэн хүүхдэд хууль эрх зүй болон сургуулийн дотоод журмын дагуу сахилгын арга хэмжээ авна.

Хүчирхийлэл үйлдсэн хүүхдийн хичээлд суух эрхийг нь түр хаах тухай

Сургуулийн захирал дараахь хэрэг үйлдсэн хүүхэд, түүний асран хамгаалагчийн саналыг харгалзан хүүхдийн хичээлд суух эрхийг нь түр хаана.

- ☑ Хоёроос дээш хүүхэд санаатайгаар байнга хүчирхийлэл үйлдсэн
- ☑ Хоёр долоо хоногоос дээш хугацаагаар эмчилгээ хийлгэх шаардлага бүхий гэмтэл учруулсан
- ☑ Мэдээлэл, мэдүүлэг өгч, хэрэгт холбогдох баримт бүрдүүлж өгсөнд өс санаж хүчирхийлэл үйлдсэн
- ☑ Сургуулийн захирал хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхийлэл үйлдсэн хүүхдээс яаралтай тусгаарлах шаардлагатай гэж үзвэл

※ Шуурхай авсан арга хэмжээний дагуу хүчирхийлэл үйлдсэн хүүхдийн хичээлд суух эрхийг түр хааснаас хойш сургуулийн захирал асуудлыг бие даан шийдсэн бол шуурхай арга хэмжээний хүрээнд тасарсан хичээлийн цагийг суусанд тооцно.

- ☉ Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг хариуцсан алба, тухайн сургуулийн багш ажилчид хүчирхийлэлд өртсөн байдал, үйлдсэн хэргийг тодруулах зорилгоор болсон явдлын талаар судалгаа явуулна
- ☉ **(Болсон явдлыг шалгах)** Болсон явдлын талаар бичгээр мэдүүлэг авч, хэрэгт холбогдсон хүүхэд, гэрчтэй уулзаж, хэрэг гарсан газар судалгаа хийн болсон явдлыг ерөнхийд нь шалгана.
 - **Тодорхойлолт** : Хэрэгт холбогдогч талууд болон гэрчийн тодорхойлолт
 - **Асуулга судалгаа** : Хүчирхийллийн хэрэгтэй холбогдогч талууд болон ангийнх нь хүүхдүүдийн дунд судалгаа явуулна.
 - **Нотлох баримт цуглуулах** : И-мэйл, чат, мэдээлийн самбар, SNS-д тавьсан бичвэр бүхий дэлгэцийн зураг, мессеж, зураг, видео бичлэг, дуут бичлэг
 - **Эмчийн бичиг, тодорхойлолт** : Хүчирхийллийн улмаас учруулсан хохирлыг нотлох бие сэтгэл зүйн байдлын тухай эмчийн бичиг, тодорхойлолт
- ☉ **(Тавигдах шаардлага)** Хүчирхийллийн хэрэгт холбогдогч талууд хоорондоо уучлал хүссэн эсэх, ял шийтгэл ногдуулах тухай, эмчилгээний зардал зэрэг асуудлыг харилцан тохиролцож, хүчирхийлэл дахин давтагдахаас сэргийлэх тухай шаардлага, хүүхэд асран хамгаалагчийн зүгээс хэргийг шийдэхэд тавих шаардлага байгаа эсэхийг лавлаж тодруулна.
 - ※ Шаардлагатай гэж үзвэл асран хамгаалагчийн зүгээс тавьж байгаа шаардлагыг сонсоод, болсон явдлын талаархи судалгааны материалд үндэслэн хэргийн тухай хангалттай ойлголтыг асран хамгаалагчид өгнө.
- ☉ **(Сургуулийн орчинд гарсан хүчирхийллийн хөнгөн, хүнд хэлбэрийг тогтоох)** Сургуулийн орчинд гарсан хүчирхийллийн хэрэгт дараахь үйлдлүүд багтаж байгаа эсэхийг харгалзан үзэж хэргийн хүнд, хөнгөн хэлбэрийг тогтооно.
 - ☑ Хүчирхийлэлд автсан хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэх
 - ☑ Хүчирхийллийн тухай холбогдох байгууллагад мэдэгдэж гомдол гаргасан хүүхдийг айлган сүрдүүлж, өс санасан үйлдэл гаргасан эсэх
 - ☑ Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг ноцтой·байнга·санаатай үйлдэгдсэн эсэх
 - ☑ Хүүхэд хийсэн хэрэгтээ гэмшиж байгаа эсэх
 - ☑ Холбогдох арга хэмжээний дагуу хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд арга хэмжээ авсан эсэх
 - ☑ Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэгт холбогдогч талууд болон асран хамгаалагчдын эвлэрсэн байдал

[Хавсралт] Олон соёлт гэр бүлийн хүүхэд(Гадаад улсад амьдарч байгаад ирсэн·Гадаад иргэний хүүхэд) болсон явдлын талаархи судалгаанд оролцоход дэмжлэг үзүүлэх


- Солонгос хэлээр тааруухан ярьдаг олон соёлт гэр бүлийн хүүхдээс болсон явдлын талаар мэдүүлэг авах үед орчуулагч болон хариуцсан багш хамт орж болно.
- Солонос хэл дээр бичгээр мэдүүлэг өгөхөд болсон явдлын талаар тодорхой тайлбарлаж бичих боломжгүй тул орчуулгатай мэдүүлгийн хуудас ашиглах юмуу эх хэл дээрээ бичиж болно.
- Харьяа хот-аймгийн боловсролын газарт Олон соёлт гэр бүлийн хүүхдэд мэргэжлийн зөвлөгөө өгдөг ажилтан байдаг бол гадаад улсад амьдарч байгаад ирсэн·гадаад иргэний хүүхэд ярилцлаганд орохдоо тусламж авах хүсэлт гаргаж болно.

СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭРЭГ ХАРИУЦСАН АЛБАНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

- Сургуулийн орчин дахь хүчирхийллийн асуудал хариуцсан алба нь болсон явдлын талаар авсан мэдүүлэгт үндэслэн сургуулийн захирал бие даан шийдвэр гаргах боломжтой эсэхийг тогтооно. Мөн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, асран хамгаалагч асуудлыг сургуулийн захирал бие даан шийдэхийг зөвшөөрч байгаа эсэхийг тодруулна.

※ Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг хариуцсан алба нь хичээлийн эрхлэгч, мэргэжлийн зөвлөгч, эрүүл мэндийн багш, сургуулийн нийгмийн ажилтан(сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг эрхэлсэн багш), эцэг эхийн төлөөллөөс бүрдэнэ. Энэ нь сургуулийн орчинд үүссэн хүчирхийллийн хэргийг шийдэх дотоод байгууллага юм.

<Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэг хариуцсан албаны шалгалтын дагуу хэрэг шийдэх журам>



Сургуулийн захирал асуудлыг бие даан шийдэх

- Сургуулийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, асран хамгаалагч Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороог хуралдуулах хүсэлгүй байгаа болон болсон явдал дараахь дөрвөн шаардлагыг хангасан хөнгөн хэрэг бол сургуулийн захирал бие даан шийдвэр гаргана.
 - ✓ Хоёр долоо хоногос дээш хугацаагаар эмчилгээ хийлгэх шаардлага бүхий бие-сэтгэл зүйн хохирол учруулсан тухай эмчийн тодорхойлолт гараагүй
 - ✓ Эд хөрөнгийн хохирол учруулаагүй, эсвэл хохирлыг даруй барагдуулсан(бие-сэтгэл зүйн эмчилгээний зардал үүнд багтана)
 - ✓ Сургуулийн орчин дахь хүчирхийлэл байнга үргэлжлээгүй
 - ✓ Сургуулийн орчин дахь хүчирхийллийн талаар өгсөн мэдээлэл, мэдүүлэг, нотлох баримтын талаар өс санасан үйлдэл гаргаагүй
- Сургуулийн захирал бие даан шийдэх үед хэрэгт холбогдогч талууд эвлэрч, хохирол учруулсан тал уулчлалт хүсэж, хүчирхийлэлд өртсөн хүүхэд түүнийг уучилж хоорондоо эвлэрэхийг хичээнэ. Мөн хүчирхийлэл үйлдсэн хүүхдийг зөвлөгөө сургалт, компани ажил, сургуулийн дотоод, гадаад сайн дурын ажил, бусад сургалтын хөтөлбөрт хамруулах, хэрэгт холбогдсон талуудын харилцааг сэргээх хөтөлбөр зохион байгуулах тохиолдол ч байдаг.

[Хавсралт] Сургуулийн захирал бие даан шийдэж хаасан хэргийн талаар Хянан шалгах хороог хуралдуулах тухай хүсэлт гаргах

Журмаараа бол хүчирхийлэлд өртсөн хүүхэд, түүний асран хамгаалагч сургуулийн захирал бие даан шийдэж, хаасан хэргийн талаар Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хорооны хурлаар авч хэлэлцүүлэх боломжгүй байдаг. Харин дараахь тохиолдолд хянан шалгах хорооны хурлаар асуудлыг хэлэлцүүлэх тухай хүсэлт гаргаж болно.

- Хүчирхийлэл үйлдсэн хүүхэд, түүний асран хамгаалагч хүчирхийлэлд өртсөн хүүхэд, асран хамгаалагчид амласан хохирлыг барагдуулаагүй
- Тухайн сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэргийг судалж шалгах үед илрээгүй өөр асуудал нэмж илэрсэн.

5

Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороогоор хэлэлцүүлж, арга хэмжээ авах

• Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороо гэж юу вэ?

- Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороо гэдэг нь сургуулийн орчинд хүчирхийлэл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд авсан арга хэмжээнд хамруулж, сахилгын арга хэмжээ авах, хэрэгт холбогдогч талуудын хоорондох маргааныг хянан шалгаж, зохицуулах үүрэг бүхий боловсролын газрын харъяа шүүх байгууллага юм
- Сургуулийн захирал бие даан шийдэх боломжгүй, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, түүний асран хамгаалагч захирал бие даан шийдвэр гаргахыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд сургуулийн зүгээс гаргасан хүсэлтийн дагуу Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороог нээж хуралдуулна.

• Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хорооны хэлэлцэх асуудал

- **(Хэлэлцэх асуудал)** Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг авсан арга хэмжээг хянан шалгах хороо нь сургууль дээр гарсан хүчирхийллийн хэргийн талаар дараахь асуудлуудыг шалгаж шийдвэрлэнэ.
 - ☑ Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гарсан хэргийн талаар арга хэмжээ авах
 - ☑ Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах
 - ☑ Хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд арга хэмжээ авч, сахилгын хариуцлага хүлээлгэх
 - ☑ Хүчирхийлэлд өртсөн, үйлдсэн хүүхдийн хоорондын зөрчил маргааныг шийдэж, зохицуулах
 - ☑ Захирлын санал болгосон сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлж, арга хэмжээ авах тухай бусад асуудал
- **(Асуудал шийдэх арга)** Хүчирхийлэлд холбогдогч талууд болон тэдний асран хамгаалагч Хянан шалгах хороонд өөрийн биеэр ирж өгсөн мэдүүлэгт үндэслэн асуудлыг шийдэх дүрмийг мөрдлөг болгоно.
 - Жич, Хэрэгт холбогдогч талуудын зүгээс хүсэлт гаргасан, зүүн баруун хязгаарын бүсийн байрлалаас шалтгаалан ирж очих хүндрэл зэргийг харгалзан үзэх шаардлагатай үед хянан шалгах процессийг утас, видео яриа, бичгээр авах аргыг ашиглаж болно.
 - Хянан шалгах хороон дээр биеэр ирэх өдөр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас захирлын зөвшөөрөлтэйгээр ирээгүй тохиолдлыг ирсэнд тооцно.
- **(Авах арга хэмжээний тухай мэдэгдэл хүргүүлэх)** Хянан шалгах хороо шалгалт явуулсны дараа холбогдогч талуудад зохих арга хэмжээ авах тухай шийдвэр гаргана.
 - Боловсролыг дэмжих газар Хянан шалгах хорооноос гаргасан арга хэмжээ авах тухай шийдвэрийг хэрэгт холбогдогч талууд болон сургуулийн захирлын нэр дээр мэдэгдэл хүргүүлж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

• Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах арга хэмжээ

Хянан шалгах хороо хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах арга хэмжээний хүрээнд доор заасан аль нэг(эсвэл хэд хэдэн) нөхцлийн дагуу шийдвэр гаргана. Үүний дараа боловсролыг дэмжих газар хүчирхийлэлд өртсөн хүүхдийн асран хамгаалагчийн зөвшөөрөлтэйгээр долоо хоногийн дотор тус арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- ✔ **Сургуулийн мэргэжлийн сэтгэл зүйчээс зөвлөгөө авахыг санал болгох** : Сургуулийн орчин дахь хүчирхийллийн улмаас оюуны сэтгэл зүйн цочролд орсон байдлаас гарахад нь туслах зорилгоор сэтгэл зүйн мэргэжлийн зөвлөгөө өгдөг сургуулийн дотоод гадаад байгууллагад хандаж зөвлөгөө өгнө.
- ✔ **Түр хамгаалалтад авах** : Хүчирхийлэл үйлдсэн хүүхэд дахин халдах, өс санах магадлал өндөр үед түр хамгаалах байр, сургуулийн зөвлөгөө өгөх танхим болон гэрт нь байрлуулж хамгаална.
- ✔ **Эмчилгээ, асаргаа** : Сургуулийн орчин дахь хүчирхийллийн улмаас үүссэн бие сэтгэлийн шархыг эмчлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагад хандаж эмчилгээ хийлгэнэ.
※ эрээр болон асаргааны төвд эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээ хийлгэсэн хугацааг тодорхой тэмдэглэсэн эмчийн бичиг зэрэг нотлох баримыг сургуульд хүргүүлнэ.
- ✔ **Анги солих** : Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, асран хамгаалагчийн саналыг харгалзан хүчирхийлэл үйлдсэн хүүхдийг өөр ангид хуваарилах арга хэмжээ авна.
- ✔ **Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалахад шаардлагатай бусад арга хэмжээ** : Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэргийн төрөл, хүүхдийн насны онцлог зэргийг харгалзан үзэж эрүүл мэнд, хууль эрх зүй, сургуулийн орчин дахь хүчирхийллээс хамгаалах байгууллагад хандаж тусламж авах тухай хүсэлт гаргана.

[Хавсралт] Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалахад шаардлагатай бусад үйлчилгээ

- **(Хичээлд суугаагүй хоногийг суусанд тооцох нь)** Сургуулийн захирал хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалалтад авах шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хамгаалалтад байх хугацаанд тасарсан хичээлийн хоногийг хичээлд суусанд тооцно. Энэ тохиолдолд эмчийн бичиг, тодорхойлолт зэрэг баримтыг бүрдүүлж өгнө.
- **(Хохирол учруулахгүй байх)** Хүүхэд хамгаалах арга хэмжээнд хамрагдсан нь сурлагын дүнгийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөхгүйгээр сургуулийн зүгээс арга хэмжээ авна. Хүчирхийлэлд өртөж, хичээл тасалдаж шалгалтанд орж чадаагүйн улмаас сурлагын дүнгийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх учиргүй. Ийм үед ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн сурлагын дүнг хянах журмын дагуу арга хэмжээ авна.
- **(Мэдээлэл өгөх)** Сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөний улмаас хамгаалалтад орох тухай шийдвэр гарсан хүүхдэд дараахь мэдээллийг өгнө.
 - Сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд дэмжлэг үзүүлэх байгууллага
 - Сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд зориулсан хөтөлбөр
 - Сургуулийн орчин дахь хүчирхийлэлд холбогдогч талуудын маргааныг зохицуулах байгууллага

• Хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд авах арга хэмжээ

Хянан шалгах хорооноос хүчирхийлэл үйлдсэн хүүхэд, түүний асран хамгаалагчийг доор заасан нэг болон хэд хэдэн сургалт арга хэмжээнд хамруулна:

- ✓ **Хүчирхийлэлд өртсөн хүүхдээс бичгээр уулчлалт хүсэх** : Хүчирхийлэлд үйлдсэн хүүхэд хийсэн хэргийнхээ талаар хүчирхийлэлд өртсөн хүүхдээс бичгээр уулчлалт хүсэх
- ✓ **Хүчирхийлэлд өртсөн хүүхэд сургуульдаа мэдэгдэж гомдол гаргасныг асуудал болгон халдах, айлган сүрдүүлэх, өс санасан үйлдэл гаргахыг хориглоно** : Хүчирхийлэл өртсөн хүүхэд сургуульдаа мэдэгдэж гомдол гаргасныг асуудал болгож халдах, хүчирхийлэл дахин давтагдах, өс санасан үйлдэл гаргахыг таслан зогсоох зорилго бүхий арга хэмжээ.
- ✓ **Сургуулийн сайн дурын ажилд оролцуулах** : Сургуулийн сайн дурын ажилд оролцож, өөрийн хийсэн үйлдэлдээ гэмших боломж олгох.
- ✓ **Нийгмийн сайн дурын ажилд оролцуулах** : Сургуулиас гадуурхи төрийн байгууллагын сайн дурын ажилд оролцуулан хариуцлага бүхий нийгмийн нэгэн гишүүн гэдгийг нь ойлгуулан, өөрийн хийсэн үйлдэлдээ гэмших боломж олгох цаг гаргаж өгөх.
- ✓ **Сургуулийн дотоод мэргэжилтний удирдлагын дор тусгай сургалтанд хамрагдаж, сэтгэл зүйн эмчилгээ хийлгэх** : Боловсролын газрын даргын нэр заасан байгууллагын тусгай сургалтанд хамрагдах юмуу сэтгэл зүйн эмчилгээнд хамрагдана. Хамрагдах хугацааг нь хянан шалгах хороо тогтооно.
- ✓ **Хичээлд суух эрхийг нь түр зогсоох** : Хүчирхийлэл үйлдсэн хүүхдийн хичээлд суух эрхийг түр зогсоох нь түүнд хийсэн хэрэгтээ гэмших боломж олгох, хүчирхийлэлд өртсөн хүүхдээс тусгаарлах, хамгаалах арга хэмжээ юм.
 - ※ Хүчирхийлэл үйлдсэн хүүхдийн тасарсан хичээлийн хугацааг хичээлд суусан цагт оруулахгүй. Эдгээр цаг хичээлд сууснаар хүлээн зөвшөөрөгдөхгүй бөгөөд тасалсанд тооцогдоно.
- ✓ **Анги солих** : Хүчирхийлэл үйлдсэн хүүхдийг хүчирхийлэлд өртсөн хүүхдээс тусгаарлах зорилгоор сургуулийн дотор өөр ангид хуваарилна.
- ✓ **Өөр сургууль руу шилжүүлэх** : Хүчирхийлэл үйлдсэн хүүхдийг хүчирхийлэлд өртсөн хүүхдээс тусгаарлах, дахин хүчирхийлэл үйлдэхээс сэргийлэх үүднээс өөр сургууль рүү шилжүүлнэ.
- ✓ **Сургуулиас гаргах** : Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд арга хэмжээ авах сургалтад хамруулах боломжгүй гэдэг нь батлагдсан үед авах арга хэмжээ(Ерөнхий боловсролын сургуулийн албан сургалтад хамрагдаж байгаа хүүхдэд үйлчлэхгүй)
 - ※ Хүчирхийлэл үйлдсэн хүүхэд авсан арга хэмжээнд хамрагдахаас татгалзаж, зайлсхийсэн тохиолдолд Хянан шалгах хорооноос нэмэлт арга хэмжээний хүрээнд боловсролын газрын даргад хүсэлт гаргаж болно.

[Хавсралт] Хүчирхийлэл үйлдсэн хүүхэд, асран хамгаалагчид зориулсан тусгай сургалт

- Хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд зориулсан тусгай сургалтад 'Авагдсан арга хэмжээний дагуу явагдах тусгай сургалт' болон 'Хүчирхийлэлд өртсөн хүүхдээс бичгээр уулчлалт гуйх', 'Сургуулиас гаргах'-аас гадна Боловсролын газрын даргын нэр заасан байгууллагын тусгай сургалтад хамруулж, сэтгэл зүйн эмчилгээнд хамруулах "Нэмэлт тусгай сургалт"-ууд байдаг.
- Хүчирхийлэл үйлдсэн хүүхдийн асран хамгаалагч ч мөн адил тусгай сургалтад заавал хамрагдана. Сургалтад хамрагдаагүй асран хамгаалагчид гурван сая вонын торгууль ногдуулна..

ТАЛУУДЫН ХООРОНДЫН ХАРИЛЦААГ СЭРГЭЭХ, МАРГААН ЗОХИЦУУЛАХ

- ◉ **(Харилцааг сэргээх)** Сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэрэгт холбогдогч талуудад болсон явдлын талаар сайтар ойлгуулаад, талуудын хоорондын харилцааг сэргээхийн тулд холбогдогч талуудыг нэг бүрчлэн уулзуулж, ярилцлага хийж харилцааг сэргээх хөтөлбөр зохион байгуулна.

 - Хэвийн харилцааг сэргээх хөтөлбөрийг албадан явуулахгүй. Юуны өмнө хүчирхийлэлд өртсөн хүүхдийн саналыг харгалзан үзнэ.
 - Талуудын хоорондын харилцааг сэргээх хөтөлбөрийг хоёр тал бүгд зөвшөөрсөн үед зохион байгуулна. Хөтөлбөр зохион байгуулагдах явцад аль нэг талаас үргэлжлэн оролцохыг татгалзсан үед хөтөлбөрийг даруй зогсооно.
- ◉ **(Маргаан зохицуулах)** Сургуулийн орчин дахь хүчирхийлэлтэй холбогдон гарсан хохирлын тухай холбогдогч тал, асран хамгаалагчдын хооронд үүссэн маргааныг Хянан шалгах хороо зохицуулж шийдвэрлэнэ.

 - **(Маргаан зохицуулах тухай өргөдөл гаргах)** Дараахь нөхцөлд хэрэгт холбогдогч талууд(хүчирхийлэлд өртсөн, үйлдсэн тал) <Маргаан зохицуулах тухай өргөдөл>-ийн маягыг бөглөж хянан шалгах хороонд хүргүүлнэ.
 - ☑ Хүчирхийлэл өртсөн хүүхдийн тал эмчилгээний төлбөр, сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр зэрэг мөнгөн тэмдэгтээр хохирол барагдуулах тухай шаардлага тавьсан.
 - ☑ Хүчирхийлэлд үйлдсэн хүүхдийн тал эмчилгээний төлбөр, сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг мөнгөн тэмдэгтээр төлж барагдуулах тухай хүсэлт гаргасан.
 - ※ Хянан шалгах хороо маргаан зохицуулах тухай өргөдөл хүлээн авнаас хойш 5 хоногийн дотор маргааныг зохицуулах үйл ажиллагааг эхлүүлж, нэг сарын дотор бүрэн шийдвэрлэнэ.
 - **(Маргаан зохицуулах үйл ажиллагаанаас татгалзах/зогсоох)** Дараахь нөхцөлд маргаан зохицуулах үйл ажиллагаанаас татгалзан, зогсоож болно.
 - ☑ Маргаанд хамаатай аль нэг тал маргаан зохицуулах ажиллагаанд оролцохоос татгалзсан
 - ☑ Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тал тухайн сургуулийн орчин дахь хүчирхийллийн хэргийн талаар иргэний хэрэг шүүх байгууллагад өргөдөл гомдол гаргасан
 - ☑ Маргаан зохицуулах тухай өргөдөлд тусгагдсан агуулга худлаа болох нь тодорхой болж, хүндэтгэн үзэх шалтгаангүй гэдэг нь батлагдсан
 - **(Маргааны зохицуулалтыг баталгаажуулах)** Маргааны зохицуулалт баталгаажсан үед хянан шалгах хорооноос маргааны агуулга, зохицуулалтын үр дүн бүхий тохиролцооны бичгийг боловсруулж талуудад мэдэгдэнэ. Маргаантай асуудал зохицуулагдан баталгаажсан нь Хянан шалгах хороог хуралдуулахгүй, хүчирхийлэл үйлдсэн хүүхэд зохих арга хэмжээг хүлээхгүй шалтгаан болохгүй бөгөөд хүчирхийлэл үйлдсэн хүүхдэд авах арга хэмжээний үеэр зөвхөн харгалзан үзэх материал болно

[Хавсралт 1] Сургуулийн орчин дахь хүчирхийллийн тухай мэдэгдэх / тусламж авах байгууллага

	<p>Өсвөр насны хүүхдэд зөвлөгөө өгөх кибер төв Хүнд байдалд орсон, сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн өсвөр насны хүүхдэд зөвлөгөө өгөх, мэдээлэл хүлээн авах утас.</p> <p>☎ 1388 🏠 www.cyber1388.kr</p>
	<p>Пүрэнь-наму сан Сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд утсаар болон кибер орчинд зөвлөгөө өгөх, хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх нэгдсэн үйлчилгээ үзүүлдэг. Мөн сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд дэмжлэг үзүүлэх SOS багийнхан хэрэгт холбогдогч талуудыг эвлэрүүлэх-маргаан зохицуулахаас гадна хэрэг шийдэх мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ.</p> <p>☎ 1588-9128 🏠 www.btf.or.kr</p>
	<p>Солонгосын хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлэх алба Хуулийн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ, үйлчлүүлэгчийг төлөөлөн шүүх байгууллагад өргөдөл, гомдол гаргаж, зарга мэдүүлэх, эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх хэрэг дээр өмгөөлөл хийх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.</p> <p>☎ 132 🏠 www.klac.or.kr</p>
	<p>Wee прожект Сургууль, боловсролын(боловсролыг дэмжих) газраас хүүхдэд зөвлөгөө өгдөг. ※ Wee class(Сургууль бүр дээр байдаг) Wee center(Боловсролыг дэмжих төвүүд дээр байдаг) – Wee school(Хот-аймгийн боловсролын газарт байрлана)</p> <p>🏠 www.wee.go.kr</p>
	<p>Турань Турань Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон гарсан хэргийг шийдэх чиглүүлэх сургалтууд зохион байгуулдаг</p> <p>🏠 www.dorandoran.go.kr</p>
	<p>Edunet T-Clear Сургуулийн орчин дахь хүчирхийллийн тухай сургалт, дадлагын материал, кибер орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, холбогдох мэдээллээр хангана</p> <p>🏠 www.edunet.net</p>
 <p>Цагдаагийн ерөнхий газрын харьяа Кибер орчны аюулгүй байдлыг хангах төв</p>	<p>Цагдаагийн ерөнхий газрын харьяа Кибер орчны аюулгүй байдлыг хангах төв Кибер гэмт хэргийн тухай мэдээлэл хүлээн авч зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ</p> <p>🏠 www.police.go.kr/www/security/cyber.jsp</p>
	<p>Аюулгүй байдал-Dream(Бага насны хүүхэд-эмэгтэйчүүд-хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх цагдаагийн төв) Сургуулийн орчин дахь хүчирхийлэл, кибер орчин дахь хүчирхийллийн тухай мэдээлэл хүлээн авч зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ.</p> <p>🏠 www.safe182.go.kr</p>
	<p>Смарт-шүим төв(Интернэтэд донтсон хүүхдэд зөвлөгөө өгөх төв) Интернэтийн хэт их хэрэглээний тухай зөвлөгөө (Зарлалын самбар, мессенжерээр дамжуулан авна) өгнө.</p> <p>🏠 www.iapc.or.kr</p>

[Хавсралт 2] Сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд дэмжлэг үзүүлэх байгууллага

(2019 оны 12 сарын байдлаар)

Бүс	Дд	Байгууллагын нэр	Хаяг	Утас	Үзүүлэх үйлчилгээ			
					Зөвлөгөө	Түр хамгаалалтад авах		Эмнэлэг
						Түр	Байрлуулах	
Орон даяар (1)	1	Хээ-малгым төв	Тэжон хот, Юусон-гу, тээгым-ру 77	+82-70-7119-4119	0	-	0	-
	2	Сөүл нэгдсэн Wee төв	Сөүл хот, жуңру-гу, сунволь-гиль 48	+82-2-3999-505	0	0	-	-
Сөүл (3)	3	Сөүл Маьмиран Wee төв	Сөүл хот, сондун-гу, пусаньжа-ру 280, Сондун Боловсролыг дэмжих газар 106 тоот	+82-2-2297-7887	0	0	-	-
	4	Сөүл Балгымиран Wee төв	Сөүл хот, Гуаньяг-гу, Намбусүнэхунь-ру 172 гиль, 97	+82-2-853-2460	0	0	-	-
Бусань (1)	5	Галдын Хуибуг төв, яаралтай үед	Бусань, Саха-гу, Хашинь Жунаун-ру 291, 1 дун, 125 тоот	+82-51-203-8116	0	-	-	-
Тэгү (1)	6	Тэдун Wee төв	Тэгү хот, Дун-гу Хуаран-ру 177-2, Тэдун эмнэлгийн өргөтгөл 1 давхар	+82-53-746-7386	0	-	-	0
Инчонь (1)	7	Инчонь хотын Wee төв (ХайрфМерөөдел Пигмаллиунь төв)	Инчонь хот, Намдун-гу, Мунэхуа-ру 169 гиль, 73, 2 давхар	+82-32-550-1703	0	-	-	-
Гуаньжү (4)	8	Гуаньжү хотын өвсөр насны хүүхдэд зөвлөгөө өгөх, халамжийн төв	Гуаньжү хот, Согу Санмүжаоу-ру 173, 5 давхар	+82-62-226-8181	0	-	-	-
	9	Маьмиымь сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв	Гуаньжү хот, Со-гу, Хуижээ-ру 888, 5 давхар	+82-62-654-3030	0	-	-	-
	10	Ай нури хүүхдийн хөгжил, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв	Гуаньжү хот, Буг-гу, Солжүг-ру 510 Санжи билдинг 4 давхар	+82-62-574-6850	0	-	-	-
	11	Хунам ИС-ийн оюутнуудад зөвлөгөө өгөх төв	Гуаньжү хот, Гуансань-гу, Хунамдэ-гиль 20	+82-62-940-5630	0	-	-	-
Тэжон (2)	12	Тэжон хотын өвсөр насны хүүхдэд зөвлөгөө өгөх, халамжийн төв	Тэжон хот, Дун-гу, Тэжон Чоньдун-ру 508, Тэжон өвсөр насны хүүхдийн төв, 6 давхар	+82-42-257-2000	0	-	-	-
	13	Тэжон хотын бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд зөвлөгөө өгөх YMCA төв	Тэжон хот, Жүн-гу, Тэхын-ру 128	+82-42-254-3038	0	-	-	-
Улсан (1)	14	Улсан хотын Боловсролын газрын харъяа Хиллинг Wee төв	Улсан хот, Улжүгүнь Оньян-ыб Оньян-ру 103, 2 давхар	+82-52-255-8190	0	0	-	-
Сэжун (1)	15	Сэжун Арам төв(Сэжун Wee төв)	Сэжун хот, Дүүм 1 ру, 116, Жуннь халамжийн нэгдсэн төв, 2 давхар	+82-44-715-7979	0	-	-	-
Кэнги (10)	16	Гүм-наму Хүүхдэд зөвлөгөө өгөх нэгдсэн төв	Кэнги-ду Бүчонь хот, Аньгү-ру 194 гиль, 14	+82-32-347-7205	0	-	-	-
	17	Нүрим өвсөр насны хүүхдийн боловсрол, халамжийн төв	Кэнги-ду, Ансан хот, Данвонгү, Гужаньдун Хуарар-ру 358, Чөлөөт төв билдинг 315 тоот	+82-31-402-4145	0	-	-	-
	18	Рапа-эл зөвлөгөө өгөх, халамжийн төв	Кэнги-ду, Ёнхонгүн Жонгү-ыб Ёнхонь-ру 81-10(Жонгү-ыб)	+82-31-832-6401	0	-	-	-
	19	Маьм-шүим төв, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв	Кэнги-ду, Ичонь хот, Сохьи-ру 91(Чанжонь дун 425-28)	+82-31-635-1279	0	-	-	-
	20	Сэтгэл зүй судалгааны төв	Кэнги-ду, Янпён гүн, Юунмунь-мён Дамунь Жунаун 1 гил, 6-1, 3 давхар	+82-31-775-5507	0	-	-	-
	21	Сүвонь хотын бага насны хүүхдэд, өвсөр насны хүүхдийн сэтгэций нэрүүл мэнд, халамжийн төв	Кэнги-ду, Сүвонь хот, Палдаль-гу, Дунмаль-ру 47 гиль, 17_1 давхар	+82-31-242-5737	0	-	-	-
	22	Тудан өвсөр насны хүүхдийн сургалтын төв	Кэнги-ду, Гуян хот Догян-гу, Жунаун-ру 633 гиль, 25	+82-31-970-0031	0	-	-	-
	23	Ханаул сэтгэл зүйн хөгжлийн төв	Кэнги-ду, Намянжү хот, Туигевонь-мён, Гёнчуньбүг-ру 544, 4 давхар	+82-31-572-6377	0	-	-	-
	24	Солонгосын боловсролын нийгэмлэг	Кэнги-ду, Ансан хот Гунду-ыб Сынду гиль 58, 2 давхар	+82-31-656-1885	0	-	-	-
	25	Ханарүл боловсрол, соёлыг дэмжих төв	Кэнги-ду, Пажү хот Чонсорүг 305, 304 тоот	+82-31-946-9069	0	-	-	-
Канвонь (4)	26	Саимдан Боловсролын төв (Сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илааршуулах төв)	Канвонь-ду, Канрын-ши, Жүмүнжинь-ыб, Ёнжү-ру 284-24	+82-33-640-6530	0	0	-	-
	27	Канвонь хүүхэд сургалтын төв	Канвонь-ду, Чүнчонь-ши Наммён Чүнжюу-ру 1394	+82-33-269-6622	0	0	-	-
	28	Чүнчонь дотуур байртай Wee төв	Канвонь-ду, Чүнчонь-ши Дунмён Манчон-ру 143 гиль, 24	+82-33-262-1607	0	0	-	-
	29	Вонжү дотуур байртай Wee төв	Канвонь-ду, Вонжү-ши Панбүмён Юунсүгүл гил 344	+82-33-761-0700	0	0	-	-

Бүс	Дд	Байгууллагын нэр	Хаяг	Утас	Үзүүлэх үйлчилгээ			
					Зөвлөгөө	Түр хамгаалалтад авах		Эмнэлэг
						Түр	Байрлуулах	
Чүнбүг (1)	30	Солонгосын хүчирхийлэлд өртсөн иргэдийг дэмжих нийгэмлэг, Чүнбүг OVA салбар	Чүнбүг Чонкү-ши Чонвонь-гү Хянгүн-ру 53 гиль 4(302 тоот)	+82-43-224-9517	0	-	-	-
Чүннам (1)	31	Мөрөөдөл Грин төв	Чүннам Чонан-ши Дуннам-гү Чондан-дун Чонсу 7 ру, 37-8 Сентрал биллижи 403 тоот	+82-70-4917-7581~5	0	0	-	-
Чонбүг (1)	32	Сэтгэлийн шарх илааршуулах төв (Чонбүг өсвөр насны хүүхдэд зөвлөгөө өгөх, халамжийн төв)	Чонбүг Чонкү-ши, Дожинь-гү Палдал-ру 346	+82-63-271-0117	0	-	-	-
Чоннам (3)	33	Гухын өсвөр насны хүүхдийн Үжү төв	Чоннам Гухын гүн, Дуниль мёнъ, Догхын ЯнЖүг гиль, 200	+82-61-830-1515	0	-	-	-
	34	Үндэсний Нажү эмнэлэг	Чоннам Нажү-ши, Сангу мёнъ Сэнам-ру 1328-31	+82-61-330-4114	-	-	-	0
	35	Сүнчонь клиник	Чоннам Сүнчонь-ши Сомүнсото гиль 2	+82-61-759-9597	-	-	-	0
Кёнбүг (3)	36	Кёнсан Бүгдү Өсвөр насны хүүхдийг дэмжих төв (Сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд дэмжлэг үзүүлэх төв)	Кёнбүг Андун-ши Чүржэжан гиль 20	+82-54-850-1075	0	-	-	-
	37	Ёнжү боловсролыг дэмжих газар, Wee төв	Кёнбүг Ёнжү-ши, Гахын-ру 165	+82-54-630-4216	0	-	-	-
	38	Чилгүг боловсролыг дэмжих газар, Wee төв	Кёнбүг Чилгүг-гүн, Узгуань-ыб, Жүнан-ру 10 гиль, 33	+82-54-979-2129	0	-	-	-
Кённам (7)	39	(Чанвонь) Ай-чува Мөрөөдлийн төв = Чанвонь боловсролыг дэмжих газар, Wee төв	Кённам Чанвонь-ши, Ыичан-гү, Жүнандэ-ру, 228 гиль, 3	+82-55-210-0461	0	-	-	0
	40	(Чиньжү) Ай-чува Мөрөөдлийн төв = Чиньжү боловсролыг дэмжих газар, Wee төв	Кённам Жинжү-шү, Бибун-ру 23 гиль, Жинжү боловсролыг дэмжих газар, 4 давхар	+82-55-740-2091	0	-	-	0
	41	(Кимхэ) Ай-чува Мөрөөдлийн төв = Кимхэ боловсролыг дэмжих газар, Wee төв	Кённам Кимхэ-ши, Саман-ру 24 гиль, баруун өргөтгөл 4 давхар	+82-70-8767-7576	0	-	-	0
	42	(Сачонь) Ай-чува Мөрөөдлийн төв = Сачонь боловсролыг дэмжих газар, Wee төв	Кённам Сачонь-ши, Шимса-ру 85	+82-55-830-1544	0	-	-	0
	43	(Түнён) Ай-чува Мөрөөдлийн төв = Түнён боловсролыг дэмжих газар, Wee төв	Кённам Түнён-ши, Гуанду-мёнъ, Жүгрим 2 ру, 25-32 Түнён боловсролын газар	+82-55-650-8025	0	-	-	0
	44	(Янсан) Ай-чува Мөрөөдлийн төв = Янсан боловсролыг дэмжих газар, Wee төв	Кённам Янсан хот, Мүлгым-ыб, Чонрюн-ру 53, Янсан боловсролыг дэмжих төв, 2 давхар	+82-55-379-3263	0	-	-	0
	45	(Мирян) Ай-чува Мөрөөдлийн төв = Мирян боловсролыг дэмжих газар, Wee төв	Кённам Мирян-дэру 1524, Ёнжэ боловсролын төв, 1 давхар	+82-55-350-1490	0	-	-	0
Чэжү (4)	46	Чэжү хотын өсвөр насны хүүхдэд зөвлөгөө өгөх халамжийн төв	Чэжү хот, Нүхён-ру 395 Даниль билдинг, 3 давхар	+82-64-725-7999	0	-	-	-
	47	Чэжү Аз жаргал, мөрөөдөл, халамжийн төв	Чэжү хот, Саммү-ру 1 гиль 5 Чонду билдинг, 3 давхар	+82-64-752-5354	0	-	-	-
	48	Даүм өсвөр насны хүүхдэд зөвлөгөө өгөх төв	Чэжү хот, Соүипү-ши, Сомүнь-ру 32	+82-64-762-1318	0	-	-	-
	49	Иньмүнь сүмида	Чэжү хот, Гүнам-ру 49, 2 давхар	-	0	-	-	-